

**ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, ТҮҮНИЙ ШАЛТГААН,
ЗӨРЧИГДСЭН ХУУЛЬ, ТОГТООМЖ.**

1. Нярав асан Б.Оюунцэцэгт 2015 оны 03 дугаар сард 100000 төгрөг, 10 дугаар сард 400000 төгрөгийн нийт 500000 төгрөгийн урьдчилгааг олгосон ба олгосон урьдчилгаанаас 5 дугаар сард 100000 төгрөг, 10 дугаар сард 300000 төгрөг бүгд 400000 төгрөгийг суутган 100000 төгрөгийн урьдчилгаа үлдсэн, галч Баатарт 2015 оны 9 дүгээр сард 350000 төгрөгийн урьдчилгаа олгож тухайн сардаа 300000 төгрөгийг суутгаж 50000 төгрөгийн урьдчилгаа үлдсэн, Санхүүгийн албаны дарга Ж.Шүрэнбаганад 2016 оны 05 дугаар сард 160000 төгрөг, 7 дугаар сард 1100000 төгрөг, 9 дүгээр сард 200000 төгрөгийн нийт 14600000 төгрөгийн урьдчилгааг тус тус олгосон ба 6 дугаар сард 300000 төгрөг, 7 дугаар сард 200000 төгрөг, 10 дугаар сард 100000 төгрөг, 11 дүгээр сард 400000 төгрөг, 12 дугаар сард 400000 төгрөг нийт 1400000 төгрөгийг суутгаж 60000 төгрөг үлдсэн нийт суутгагдаагүй 210000 төгрөгийн урьдчилгааг тайлан балансад авлагаар тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 /Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ./ 14.4.2-д /бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага/ дэх заалтыг зөрчсөн байна.

2. 2016 оны 05 дугаар сарын 17-ны А/11 дугаар тушаалаар Б.Гончигт ЭБАТ-ны 20 хувийн нэмэгдлийг 40 хувь болгосон, 2016 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн А/108 дугаар тушаалаар татварын байцаагч Б.Энэбишд 40 хувь олгох тушаал хэзээнээс эхэлж олгох нь тодорхойгүй байна.

3. 2015 оны тайлан балансын малын тэжээл дансанд байгаа 600.0 мянган төгрөгийн үлдэгдлийг тооллогын бүртгэлд бүртгээгүй.

4. Няравын дансанд холбогдох зардлуудыг шилжүүлсэн ч бэлэн мөнгөний гүйлгээний тайлан гаргаагүй, хувь хүний орлогын албан татвар суутган тооцоогүй

5. Анхан шатны баримтууд болох орлого зарлагын баримтуудыг дугаарлаагүй,

6. Санхүүгийн албаны дарга Ж.Шүрэнбаганад 2015 оны 12 дугаар сарын 25-аас аймгийн төвд малын тоо тушаах ажлаар ажиллах үеийн албан томилолтын зардал олгохдоо буудлын баримтгүй 30000 төгрөг олгосон.

7. Нэмэлт санхүүжилтийн дансаар хийгдсэн гүйлгээнүүдийн анхан шатны баримтуудыг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн тайлбар өгч байгаа ба санхүүгийн баримтанд дансны хуулганаас өөр баримт байхгүй байна.

8. 2015 онд ИТХ-ын ажлын албаны 3 ажилтны хүүхдэд 33000 төгрөгийн бэлгийг төсвөөс олгосон.

9. 2015 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 38 дугаар тушаалаар газрын даамал П.Мягмарсүрэнгийн жирэмсний амралт хүлээлцэх комисс томилсон ба ажил орлон гүйцэтгэх талаар төсөв захирагчийн шийдвэргүй байхад 2015 оны 12 дугаар

сард 196577 төгрөг, 2016 оны 1-6 дугаар саруудад сар бүр 196577 төгрөг нийт 1376039 төгрөгийг олгосон байна.

10. 2015, 2016 онуудад багийн дарга нарын онцгой нөхцөлийн нэмэгдлийг сар бүр 15 хувиар олгосон ч бууруулах талаар шийдвэр гаргаагүй байна./2015 онд Г.Цогтбаярт 104331 төгрөг, Д.Алтанзулд 104331 төгрөг, Ш.Эрхэмбаярт 104331 төгрөг, Ч.Цэрэннадмидад 104331 төгрөг, 2016 онд Г.Цогтбаярт 807476 төгрөг, Д.Алтанзулд 913451 төгрөг, Ш.Эрхэмбаярт 913451 төгрөг, Ч.Цэрэннадмидад 887501 төгрөг нийт 3939203 төгрөг / Тамгын газрын няравт нүүрс буулгах, олгох үеийн илүү цагийн хөлсийг олгосон ч илүү цагийг бүртгэсэн бүртгэл байхгүй байна.

11. Орон нутгийн төсвийн байгууллагуудын 2015, 2016 онуудын нягтлан бодох бүртгэлийн журнал, туслахуудыг үдэж архивлаагүй программ гэмтэн хэвлэх боломжгүй болсон байна.

Дээрх зөрчлүүд нь Монгол Улсын Төсвийн тухай хуулийн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-7-д “Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгахыг хориглоно”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т “санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах”, Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ыг гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн